

# “АДУУНЧУЛУУН” ХК-ИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН -2018 ОН

Илтгэгч: Гүйцэтгэх захирал Ш.БАЯСГАЛАН  
“АДУУНЧУЛУУН” ХК



## **КОМПАНИЙН ЕРӨНХИЙ ТАНИЛЦУУЛГА**

**Компанийн оноосон нэр:** “Адуунчулуун” ХК

**Үйл ажиллагааны чиглэл:** Нүүрс олборлох, борлуулах

**Компанийн албан ёсны хаяг:** Дорнод аймаг, Хэрлэн сум 8-р баг, өөрийн байр

e-mail: [info@aduunchuluun.mn](mailto:info@aduunchuluun.mn)

Санал хүсэлт: [murun@aduunchuluun.mn](mailto:murun@aduunchuluun.mn)

### **Компанийн удирдлага:**

ТУЗ-ийн дарга Баттогтох овогтой Шатар

Гүйцэтгэх захирал Шатар овогтой Баясгалан

**Үүсгэн байгуулагдсан огноо:** 1955 он

**Ажилтны тоо:** 158

**Дүрмийн сан:** 891,332,700 төгрөг

**Хувьцааны тоо:** 3,151,304

**Компанийн эрхэм зорилго:** Хэрэглэгчдийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн нүүрс олборлож, борлуулах замаар ашигтай ажиллаж, хувьцаа эзэмшигчдийн хөрөнгийг өсгөж, тэдний ашиг сонирхлыг ханган ажиллах нь компанийн үндсэн зорилго мөн.

Чанартай бүтээгдэхүүн, шуурхай үйлчилгээ, хэрэглэгч бүрт хүрч ажиллах.



## ҮНДСЭН ҮЙЛДВЭРЛЭЛ

"Адуунчулуун" ХК-ийн хамт олон 2018 онд аймаг орон нутгийн хэрэглэгчдийг өөрсдийнх нь захиалга гэрээний дагуу хэрэгцээт нүүрсээр тасалдуулахгүй хангах үндсэн үүргээ ханган биелүүлж ажилласан.

Манай компани 2018 онд 600.0 мян.тн нүүрс олборлох, 1400.0 м<sup>3</sup> хөрс хуулах, нийт 1904.2 мян.м<sup>3</sup> уулын цулын ажлыг хийж гүйцэтгэхээр төлөвлөсөн.

Төлөвлөснөөс 533.6 мян.тн нүүрс олборлож 66.4 мян.тн-р, 841,1 мян.м<sup>3</sup> хөрс хуулж 558,9 мян.м<sup>3</sup>-р тус тус буурсан гүйцэтгэлтэй гарч байна.

2017 онтой харьцуулбал нүүрс олборлолт биет хэмжээгээр 7,2 мян.тн-р өссөн, хөрс хуулалт биет хэмжээгээр 420.8 мян.м<sup>3</sup>-р буурсан үзүүлэлттэй гарч байна.

Үзүүлэлт	Х/нэгж	2017 он	2018 он		Зөрүү		Харьцуулалт /%-иар/	
			төлөв	гүйц	2017-с	төл-с	2017с	төл-с
<b>Нүүрс борлуулалт</b>	<b>мян.тн</b>	<b>526,4</b>	<b>600,0</b>	<b>533,6</b>	<b>7,2</b>	<b>-66,4</b>	<b>1,4</b>	<b>-11,1</b>
"ДБЭХС" ХК	мян.тн	440,1	520,0	465,0	24,9	-55,0	5,6	-10,6
Ахуй	мян.тн	86,3	80,0	68,6	-17,7	-11,4	-20,5	-14,3
Хөрс хуулалт	мян.м <sup>3</sup>	1261,9	1400,0	841,1	-420,8	-558,9	0,0	0,0
Уулын цул		1704,3	1904,2	1289,5	-414,8	-614,7	-24,3	-32,3


"ДБЭХС" ТӨХК-д гэрээний дагуу 520.0 мян.тн нүүрс нийлүүлэхээс 465.0 мян.тн-ыг нийлүүлж, төлөвлөснөөс 55.0 мян.тн-р буурч, ахуйн хэрэглэгчдэд 80.0 мян.тн-ыг нийлүүлэхээс 68.6 мян.тн-ыг нийлүүлж, төлөвлөснөөс 11.4 мян.тн-р буурсан байна.

Нүүрсний нийт олборлолтын 87.1%-ийг "ДБЭХС" ХК-д, 12.9%-ийг айл өрх, ААНэгжүүдэд борлуулсан.

2012-2018 онуудад олборлож борлуулсан нүүрсний хэмжээг дараах графикаар харьцуулж харууллаа. Графикаас харвал 2016 онд "ДБЭХС" ТӨХК-д, 2017 онд айл өрх, албан байгууллагуудад хамгийн их хэмжээгээр борлуулалт тус тус хийсэн байна. Тайлант хугацаанд хийгдсэн борлуулалт өмнөх онтой харьцуулбал өссөн үзүүлэлттэй боловч ахуй хэрэгдэгчидийн борлуулалт 2017 оноос 17.7 мян.тн-р буурсан харагдаж байна. Үүнд "НАЙНГИ" ХХК болон МАК ХХК-ийн уурхай руу борлуулалт хуваагдсантай холбоотой.



### 2012-2018 оны нүүрс борлуулалт /мян.тн/



2018 онд ДБЭХС ТӨХК-д, ААН, айл өрхүүдэд 600.0 мян.тн нүүрс нийлүүлэх байсан боловч 66.4 мян.тн нүүрсээр буурч, өмнөх оноос 7.2 мян.тн нүүрсээр өссөн үзүүлэлттэй байна.

### Хөрс хуулалт



Хөрс хуулалтын ажил өмнөх онуудтай харьцуулсан байдлаар дээрх графикаар харууллаа. Үүнээс харахад 2017 онд 1261.9 м³ хөрс хуулсан байна. Өмнөх онтой харьцуулбал тухайн цаг үеийн асуудалаас болж хөрс хуулалтын ажил саатсан бөгөөд 420.8 м³ буурсан харагдаж байна.

### УУЛЫН ХЭСЭГ

**Нүүрс олборлолтын ажлын хүрээнд хийгдсэн ажлууд:**



2018 оны нүүрс олборлолтын ажлыг 1 дүгээр сарын 02-ны өдрөөс 12 дугаар сарын 29-ыг хүртэл 251 хоногийн хугацаанд нүүрсний 5 түвшингээс ЭКГ-4,6Б маркийн №986, ЭКГ-5А маркийн №12273, №10823, №8690, №784 экскаваторуудаар “Дорнод бүсийн эрчим хүчний систем” төрийн өмчит хувьцаат компанид болон ахуйн хэрэглэгчидэд нүүрсийг нийлүүлж, үйлдвэрлэлийн төлөвлөгөөг **94,3%**-иар биелүүлж ажилласан.

“ДБЭХС” ТӨХК нь 2018 онд 520,0 мянган тонн нүүрс худалдан авахаар захиалга өгч, 9, 10 дугаар саруудад Дорнод МАК уурхайгаас туршилтын журмаар нүүрс авч, нүүрсний нийлүүлэлтийг хязгаарласнаас үйлдвэрлэлийн үндсэн төлөвлөгөө биелэгдэхгүй байх гол шалтгаан болсон гэж дүгнэж байна.

#### **Хөрс хуулалтын ажлын хүрээнд хийгдсэн ажлууд:**

2018 оны 5 дугаар сарын 3 -ны өдрөөс 12 дугаар сарын 7 -ны хүртэл 173 хоногийн хугацаанд хөрс хуулалтын ажил хийж гүйцэтгэлээ.

Энэ хугацаанд хөрс хуулалтын ажлыг уурхайн ажлын хойд болон зүүн бортонд явуулж, хөрсний түвшингүүдэд дундажаар 25-36 метрийн өргөн ахилт хийж, хөрс хуулалтын ажлын төлөвлөгөөг 95,1%-иар биелүүлж ажилласан байна.

Мөн Гор 760-н зүүн хэсэгт Экскаватор №10982-р 300м газарт 20 м өргөнтэй нийт 40 орчим мянган м<sup>3</sup> хөрс хучилтын ажил хийгдсэн. Ингэснээр хөрс хуулалтын ажил эрт эхлэх боломж нөхцөл бүрдсэн.

#### **АВТОЗАСВАРЫН ХЭСЭГ**

Хүнд даацын автосамосвалуудын тээвэрлэсэн ачаа, хийж гүйцэтгэсэн ажлын хэмжээ:

- “ДБЭХС” ХК-нд 489731,9 тн нүүрс тээвэрлэсэн.
- Хөрс хуулалтын ажлаар 863926,2 м<sup>3</sup> дотор овоолгод тээвэрлэсэн.
- Ахуйн хэрэглэгчид гэрээт газруудад 5980.0 тн нүүрс тээвэрлэсэн.
- Нүүрсний таазны цэвэрлэгээнд 36109,2 м<sup>3</sup> ачаа тээвэрлэсэн.
- Өөрийн Бутлуурт 53499,4 тн нүүрс тээвэрлэсэн.

Нийт 1356789,4 м<sup>3</sup> уулын цул 81048,0 рейс тээвэрлэх ажлыг хийж гүйцэтгэв.

2018 онд хийж гүйцэтгэсэн ажлаас дурьдвал:

1. Компанийн хэмжээнд бүртгэлтэй нийт тээврийн хэрэгсэл механизмуудыг Авто тээврийн хяналтын улсын үзлэгт бүрэн хамруулсан.
2. Засварын гражийн 4ш хаалга, аж ахуйн гражийн 3ш хаалга, зогсоолын гражийн 2ш хаалга тус бүрийг дулаалж засварлан гражийн хагарсан 11ш цонхыг шиллэж бүрэн бүтэн болгосон.
3. Засварын яамкануудын гэрэл гэрэлтүүлгийг сэргээн шинээр тавих ажлыг хийж гүйцэтгэсэн.
4. Автозасварын гражийн гэрэлтүүлгийг бүрэн засварласан.
5. Засварын гражийн хаалгануудад гаднаас орох хүйтэн агаарыг хязгаарлах зорилгоор 3 хаалганд 6 ширхэг бүхий хөшиг хийсэн.
6. Автозасварын хэсэг нь Уулын хэсгээс автогрейдерийг нь өөрийн хэсэг цехт авч уурхайн сайжруулсан шороон замыг засварлах, өргөсгөх хажуугийн усны хаялгын каналыг татах зэрэг зам засварын ажлыг хийж гүйцэтгэсэн.
7. Автомат нүүрсний бүтээлгийг нийт 14 автосамосвалд хийгээд байна.





### ЦАХИЛГААН САНТЕХНИКИЙН ХЭСЭГ

Цахилгаан сантехникийн хэсэг нь 2018 онд дараах ажлыг хийж гүйцэтгэв.

#### **Цахилгаанчидын хийж гүйцэтгэсэн ажил.**

- ЛЭП-8-р шугамын секционы хуучин якноог засварт оруулж нөөц якно бэлтгэн, шинээр засварласан якно тавьж ажилд оруулсан.
- Зөөврийн модон шонгийн төмөр чарга 2ш-ийг шинээр хийж ашиглалтанд оруулсан.
- Нийт урсгал засвараар 6ш якно засвар үйлчилгээ хийсэн.
- Хувцас угаалгын машины чанар, эдэлгээ муудсан бүрэн задалж засвар үйлчилгээ хийж, гэмтлийг тухай бүрд нь засварлан ажилласан.
- Тэсрэх материалын агуулах, ШТС-ын газардуулгын эсэргүүцэл хэмжилт хийсэн.
- Гал тогооны дотор цахилгаан монтаж, шит зэргийг шинээр монтаж хийсэн.
- ЛЭП-7,8-р шугамын утасны хэт унжилт шонгийн хазайлт зэргийг засварлаж 2ш бетонон шон тавьсан, зумпфны шилжүүлэлттэй холбогдолтой зарим суурин модон шонгуудыг шилжүүлсэн.
- Экскаваторуудын кабельд ус чийгнээс хөндийрүүлэх, мөн машин техникүүд кабель дайрах асуудлуудаас сэргийлж газраас хөндийрүүлэх ямаа хийсэн (36ш).
- Уурхайн байр №-53,54,55-р байрнуудын орцны цахилгаан шит засварлаж, мэдрэгчтэй LED гэрэл нийт 70ш гэрэл шинээр хийсэн.
- Уурхайн нүүрс тээвэрлэх засмал зам дагуу төмөр замын рейсээс уурхайн харуулын 1-р пост хүртэлх нийт 1100м газарт 20ш (100w LED) гэрэл хийсэн. Мөн контоорын гадна талбайд байх 2 гэрлийн шонг асааж ашиглалтанд оруулсан.
- Авто засварын гражын дотор болон гадна гэрэлтүүлэг шинээр хийсэн. Мөн Авто засварын граж яамны гэрэлтүүлэг шинээр сольсон.
- Харуул, зэвсэг, клонк, пүүний гэрэл цахилгааны засварын ажилууд тухайн саруудад хийгдсэн. Үүнд зэвсэгийн скаладанд 5ш 30w-ын гэрэл, пүүний гадаах гэрэл 4ш мөн ажилчидын хувцас солих коридор, ИТА өрөө, контоорын гэрэлтүүлэг шинээр сольж сэргээн засварласан. Хэгэгцээний халуун усны



бойлуур шинээр хийхтэй холбогдон цахилгаан шит шинээр сэргээн засварласан.



**Экскаваторуудын техник үйлчилгээ, хөдөлгүүр, генераторын засвар үйлчилгээний ажил.**

- ❖ ЭКСКАВАТОР №784-ийн 5 машин агергатад жилийн их засварын ажлыг хийж гүйцэтгэсэн. Үүнд ерөнхий хөдөлгүүр, генераторуудын үндсэн болон туслах туйлуудыг авч цэвэрлэн изоляцыг шинээр хийж монтажилсан, якориудын цэвэрлэгээ үйлчилгээ хийсэн, Коллекторуудыг токароор өнгөлж ламмелуудыг сэргээн засварласан.
- ❖ ЭКСКАВАТОР №8690-ийн ДПЭ-52 (хода) явахын хөдөлгүүр их засварын ажил хийж гүйцэтгэсэн.
- ❖ ДЭ-816 (подёом) өргөхийн хөдөлгүүр 1ш, засвар үйлчилгээ хийж нөөцөнд бэлтгэсэн. Үүнд: Ц.Д.Станцын токарын суурь машинд подёомын хөдөлгүүрэн якорь өнглүүлж, ерөнхий хөдөлгүүрийн 2ш том таг, 2ш жижиг таг нийт 4 ш зоруулж бэлтгэсэн.
- ❖ ДПВ-52 (поворот) эргэхийн хөдөлгүүр 2ш бүрэн засвар үйлчилгээ хийж нөөцөнд бэлтгэсэн.
- ❖ ЭКСКАВАТОРУУДАД гагнуурын аппарат залгах хүчний разетка тавьсан.
- ❖ ЭКСКАВАТОРУУДЫН ЯКНОНУУДАД хориглох анхааруулах плакат тавьсан.
- ❖ ЭКСКАВАТОР №784-н хөл педаль шинээр сольсон.
- ❖ ЭКСКАВАТОР №10823,986,8690,10982,784,12273-д жилийн их засварын ажлийг хийсэн.
- ❖ ЭКСКАВАТОРЫН ЕРӨНХИЙ ХӨДӨЛГҮҮР(АЭ-113-4У2) 2ш засварласан. Үүнээс (Экс-№12273-д 1ш, нөөцөнд 1ш), Экс-№12273-д подёомын генератор 1ш бүрэн засвар үйлчилгээ хийсэн.
- ❖ ЭКСКАВАТОР №784-ийн повротын генератор(ДПВ-52У2), сэргээгчийн генератор(2МП542-1/2М-У2) -уудыг бүрэн засвар үйлчилгээ хийсэн. Үүнд: үндсэн болон туслах туйлуудыг авч цэвэрлэн изоляцыг шинээр хийж монтажилсан, якориудын цэвэрлэгээ үйлчилгээ хийсэн, Коллекторуудыг токароор өнгөлж ламмелуудыг сэргээн засварласан.
- ❖ Напорын хөдөлгүүр (ДПЭ-52) 2ш бүрэн засвар үйлчилгээ хийж нөөцөнд бэлтгэсэн.



### Сантехникчидийн хийж гүйцэтгэсэн ажил.

- ❖ Уурын зуух бүрэн засвар хийсэн. (НР-18-54)-ын тогоо 2ш шинээр хийж гүйцэтгэв.
- ❖ Улаан худагаас нааш цэвэр усны шугам 2 газар цоорсоныг сэргээн засварласан.
- ❖ Хуучнаар цэвэрлэгчийн өрөө байсан өрөөг засвар хийж ажилчидын угаалтуурын хүчин чадлыг нэмэх зорилгоор шинээр 4ш угаалтуур хийсэн.
- ❖ Аж ахуйн гражын хэрэглээний ус авах шугамыг беладын гражд шилжүүлэн тавьсан.
- ❖ Консерваци, бульдозер ковшын грашын дулааны шугамыг Ф70-ын турбаагаар шинэчлэн 9ш регестр хийсэн.
- ❖ Хэрэглээний халуун усны бойлуур шинээр хийсэн.
- ❖ Зумпф-нд ашиглаж байсан хөөх помп нацосыг сэргээн засварлаж нөөцөнд бэлдсэн.

### Мужааны засвар үйлчилгээ хийж гүйцэтгэсэн ажил.

- ❖ Пронтер ДОА-6966 –д зөөврийн битүү бутка хийж тоноглов. Пронтер ДОА-6966 машиныг 2018 оны 2-р сард Уулын хэсэгт хүлээлгэн өгсөн.
- ❖ Пикап ДОА-5544 машиныг уулын хэсгээс хүлээн авж техник үйлчилгээ хийж, бүтэн будаг замаскны ажил хийсэн.



- ❖ Гражын дээврийн засварын ажилыг барилгын ажилчидтай хамтран гүйцэтгэсэн.
- ❖ Усан оргилуурын сандалнуудад 2ш сүүдрэвч хийсэн.
- ❖ Экскаваторуудын цонх шилэлсэн. Үүнд: Экс-10823 –ын цонх бүтэн засвар хийсэн.
- ❖ Скаладны үүдний сэлбэгийн лангууг шинээр хийж засварласан.
- ❖ Контоор, грашуудын хаалга цонх сэргээн засварласан.
- ❖ Нярав, компьютерийн инженер, ерөнхий инженер, санхүүчидийн өрөөнүүдэд вакум цонх шинээр хийсэн.

### БАЙГАЛЬ ОРЧИНД ХИЙСЭН АЖИЛ

6.0 га талбайн техникийн /үүнээс 4.1 га талбай нь хуучин техникийн нөхөн сэргээлт хийж байсан талбай ба дахин 4,1-га талбайд техникийн нөхөн сэргээлт хийсэн/ 3.7-га талбайд агротехникийн боловсруулалт хийн олон наст ургамлын 150 кг холимог үр тариалан суулгасан. 3.7 га биологийн талбайгаас 2.0 га талбайд нь хуучин биологийн нөхөн сэргээлт хийж байсан талбай ба дахин олон наст ургамлын үр тарьж ургуулсан. Шинээр 1.9 га талбайд техникийн нөхөн сэргээлт хийсэн. Нөхөн сэргээлтэнд дагуурын өлөнгө, ерхөг, согоовор, царгас зэрэг олон наст ургамалууд ургаж энэ жилийн байгаль цаг агаарын тааламжгүй халуун хуурай нөхцөлд ургамлын гарц 70%-тай байлаа. Мөн нэмж хайлаас мод 50ш тарьсан.





**ХӨДӨЛМӨР АЮУЛГҮЙ БАЙДАЛ ЭРҮҮЛ АХУЙН ТАЛААР ХИЙЖ ГҮҮЦЭТГЭСЭН АЖИЛ:**

Тус компани 2018 онд ХАБЭА-д нийт 97.1 сая.төгрөг зарцуулсан байна.

*А. Техник зохион байгуулалтын арга хэмжээний хүрээнд*

1. Галын аюулаас урьдчилан сэргийлэх зорилгоор ажлын байрууд дахь гал унтраагуулд 2018 оны 03-р сард шалгалт хийж гурван хэсэг болон захиргаа аж ахуйд нийт 27 ш гал унтраагуур, мөн 09-р сарын сүүлчээр галын бэлэн байдлын үзлэг явуулж ажлын байруудад нөхөн гал унтраагуур АВС-4 –г 13 ш тус тус олгожээ. Галын шланг Ф50мм\*20м 10ш захиалан гал унтраах ажилд заримыг ашиглаж байна.
2. Компанийн хэмжээнд ажлын байрны эрсдлийн үнэлгээг Дорнод аймаг дахь Политехник коллежийн Хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны багаар хийлгэсэн.
3. Уурхайн орчин, байгаль орчны бохирдолтын хяналт шинжилгээг Аймгийн УЦУОША – аар нэг удаа хийлгэж 1135000 төгрөгөөр, ундны ус болон хоолны дээжинд нянгийн шинжилгээг МХГ –ын лабораторид хийлгэв.

*Б.Ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслээр хангах арга хэмжээний хүрээнд*

1. Ажлын тусгай хувцас: үүнээс зуны өмд цамц 120 хос, зуны гутал 129 хосыг компанийн ажилтнуудад олгосон .



2. Өвлийн улиралд 119 хос ажлын өмд цамц, 116 хос ажлын гутал жагсаалтаар болон шаардахаар өгчээ.
3. Компанийн ажиллагсдад гар нүүрийн болон эдийн саван 1599 ширхэг, ажлын бээлий 7542 хосыг олгожээ.
4. Цахилгаан монтоёрын өндрийн бүс, хамгаалалтын резинэн шаахай, болон тогтмол хэрэглээний хамгаалах хэрэгслэлүүд шинээр худалдан авсан.
5. Ажлын тусгай хувцасыг тогтмол угааж цэвэрлэхэд зориулж жилийн хугацаанд тогтсон нормийн дагуу 264 кг угаалгын нунтаг, 325 кг техникийн код хэрэглэжээ.
6. Компанийн хэмжээнд газардуулгын хэмжилтийг 1 удаа хийн хэмжилтийн акт гаргасан.

*В.Ажиллагсдын халуун хоол, хор саармагжуулах хүнсний бүтээгдэхүүнээр хангах арга хэмжээнд*

1. "Хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлд ажиллах ажиллагсдад (экскаваторын машинч, эксаваторын туслах машинч, бульдозерчин, дугуйт ачигч, цахилгаанчин, хүнд даацын автомашины жолооч, засварчин, кранчин, аккумуляторчин, токарчин зэрэг) компанийн туслах аж ахуйгаас сүү, тараг XII-IV саруудад цагаа олгож, витаминжуулахад 2258000 төг зарцуулжээ.
2. Компанийн ундны усны эрүүл ахуй, хоолны амт чанарыг "Мэргэжлийн хяналтын газрын лаборатори"-т шинжилгээ өгч дүгнэлт гаргуулсан.

*Г.ХАБЭА зааварчлага, сургалт, хяналт шалгалтыг зохион байгуулах ажлын хүрээнд*

1. ХАБЭА-н нийт ажилтны сургалтыг Дорнод Политехник Коллежид Хөдөлмөрийн аюулгүй байдлын багийн багш нараар 2018 оны 03 дугаар сарын 03 өдрөөс 3 долоо хоног амралтын өдрөөр үргэлжилсэн хөтөлбөрийн дагуу явуулахад 122 ажилтан хамрагдаж 100.0 % амжилттай оролцов. Тус компанийн краны аюулгүй ажиллагаа хариуцагч, сумт болон гүүрэн краны оператор, оосорлогч дохиочны үнэмлэх сунгуулах, давтан болон эхлэн суралцах нийт 26 ажилтныг "ОАКС" ХХК- тай гэрээ байгуулан сургалтад хамруулсан. Цахилгаан тоног төхөөрөмжтэй харьцаж ажилладаг ажилтныг сургалтад хамруулан шалгалт авч ажиллах эрхийн зөвшөөрөл олгосон
2. 2018 онд ХАБЭА урьдчилсан зааварчлагыг 47 иргэнд, үүнээс тус уурхайд шинээр ажилд орсон 11 хүнд зааварчилга өгчээ.
3. ХАБЭА ээлжит давтан зааварчлагыг компанийн нэгж хэсгүүд улирал бүр өгч ажилласан байна.
4. Уурхайн тоосжилт ихтэй орчинд ажиллагч ажилтнууд амьсгал хамгаалах хэрэгслийг тогтмол хэрэглэх явдал хэвшил болоогүй. Замын тоосжилд дарах усалгааг тогтмол хийж байсан.

*Д. Ажиллагсдын эрүүл мэндийг хамгаалах ажлын хүрээнд*

1. Нийт ажиллагсдыг эрүүлжүүлэх, өвчлөлийг бууруулах зорилгоор ажлын байранд эмчилгээ сувилгаа эм тариа хийх, анхны тусламж үзүүлэх 5752914 төгрөг зарцуулжээ.
2. Улсын хэмжээнд зохион байгуулагдаж буй насны ангилал тус бүрээр Эрүүл мэндийн урьдчилсан үзлэгт хамруулах ажилд 78 ажилтан оруулсан.
3. Компанид 2018 онд үйлдвэрлэлийн осолгүй ажилласан жил боллоо. Компанийн ажлын байруудад эрсдэлийн үнэлгээг Дорнод аймаг дахь Политехник Коллежийн Хөдөлмөрийн аюулгүй байдлын багаар хийлгэсэн.



## **КОМПАНИЙ ХҮНИЙ НӨӨЦ, БҮТЭЦ ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТАЛААР:**

Захирлын 2018 оны 3-р сарын 01-ний өдрийн А/16 тоот тушаалаар удирдлагын бүтцийг 3 хэлтэс, 4 хэсгийн зохион байгуулалттай, 158 ажилтны орон тоотойгоор баталж мөрдүүлж ажилласан. Нийт 57 ажлын байранд 155 хүний орон тоотойгоор ажилласан. Үүнээс:

- Удирдлага-11
- ИТА-14
- Оператор-61
- Туслах ажилтан- 11
- Үйлчилгээний ажилтан-7

*Насны ангилалаар авч үзвэл:*

- 18-25 нас- 9
- 26-40 нас- 69
- 40-60 нас - 50
- 60-аас дээш нас -3
- Хөгжлийн бэрхшээлтэй - 5

*Ажлын байрны нөхцөл:*

- Хэвийн- 43
- Хэвийн бус - 112

*Шагнал, урамшуулал:*

- ✓ Алтан гадас-1 ажилтан
- ✓ Тэргүүний мастер – 4 ажилтан
- ✓ Аймгийн Тэргүүний ажилтан – 5 ажилтан
- ✓ Чойбалсан хотын Тэргүүний ажилчин – 2 ажилтан тус тус шагнагдсан

байна.

*Хөдөлмөрийн харилцаа, зөрчил:*

Монгол улсын хууль тогтоомжууд болон компаний дотоод журам, хамтын гэрээний дагуу үйл ажиллагаагаа явуулж Компаний хэмжээнд шинээр ажилд орсон 11 ажилчинтай хөдөлмөрийн гэрээ байгуулж тэдэнд байгууллагын дотоод журам болон хөдөлмөрийн хууль тогтоомжийн талаар зөвлөмж, зааварчилгаа өгөгдсөн.

2018 онд компанийн Захирлын нийт 90 тушаал гарсан. Үүнээс 10 нь А буюу үйл ажиллагааны чиглэлтэй тушаал, 86 нь Б буюу боловсон хүчин, хүнтэй холбогдолтой тушаал гарсан. Хөдөлмөрийн хууль, дотоод журам зөрчсөн 34 хүн сахилгын зөрчил гаргасан. Гаргасан зөрчлийг ангилвал:

- Ажил тасалсан
- Ажлын байраа орхиж явсан, сэлгүүцсэн
- Ажлаас хожимдсон, эрт явсан
- Ажлын байранд архи уусан, ажилдаа согтуу ирсэн
- Ажлын хариуцлага алдсан

Дээрхи зөрчлүүдэд

- Сануулах – 1 хүн



- 1 сарын цалин 20% бууруулах – 7 хүн
- 2 сарын цалин 20% бууруулах – 11 хүн
- 3 сарын цалин 20% бууруулах – 10 хүн
- Ажлаас халах - 5 хүн тус бүрт сахилгын шийтгэл ногдуулжээ.

### **САНХҮҮГИЙН ТАЙЛАН**

Тайлант хугацаанд нийт 8 540.0 сая.төг-ийн орлого орж, 7 760.2 сая.төг-ийн зардал гаргаж ажилласан. Өнгөрсөн онтой харьцуулбал орлого 259.2 сая.төг буюу 3.1%-иар, зардал 129.2 сая.төг буюу 1.7 %-иар тус тус өссөн байна. Иймээс татвар төлөхийн өмнөх ашиг өнгөрсөн оноос 130. сая.төг-р өссөн үзүүлэлттэй гарч байна.

Үзүүлэлт	Х/нэгж	2017 он	2018 он	Харьцуулалт	
				тоо	%-р
Нийт орлого	сая.төг	8 280,8	8 540,0	259,2	3,1
Нийт зардал	сая.төг	7 760,2	7 889,4	129,2	1,7
ТТӨ ашиг	сая.төг	520,6	650,6	130,0	25,0

### **Өртөг зардал:**

Тайлант хугацаанд нийт 7 889.4 сая.төг-ийн зардал гаргаж ажилласнаас үндсэн үйлдвэрлэлд 6 415.0 сая.төг, удирдлагын зардалд 583.4 сая.төг, үйлдвэрлэлийн бус үйл ажиллагаанд 891.0 сая.төг зарцуулсан байна.

Нийт зардлыг доорх хүснэгтээр задалж харуулав.

Өнгөрсөн онтой харьцуулахад нийт зардал 129.2 сая.төг-р өссөн. Үүнээс үндсэн үйлдвэрлэлийн зардал 324.6 сая.төг-р буурч, үйл ажиллагааны бус бусад зардал 261.3 сая.төг-р өсч, удирдлагын зардал 92.5 сая.төг-р өссөн үзүүлэлттэй гарсан.

Үйл ажиллагааны бус зардалд ТУЗ-ийн тогтоолын дагуу эмчилгээний зардалд зориулж 235.0 сая төгрөгийн буцалтгүй тусламж олгосон бөгөөд үүнийг дагаад үйл ажиллагааны бус зардал өссөн харагдаж байна.

№	Зардлын үзүүлэлт	2017 он	2018 он	Зөрүү	Зардалд эзлэх хувь
1	Түлш	831,6	929,6	97,9	14,5
2	ШТМатериал	157,1	178,1	21,0	2,8
3	Бензин	108,0	149,1	41,1	2,3
4	Сэлбэг	1469,5	1394,0	-75,5	21,7
5	Урсгал засвар	339,7	254,8	-84,9	4,0
6	Газар ашиглалт түрээс	147,0	139,9	-7,1	2,2
7	Үндсэн ба нэмэгдэл цалин	1598,7	1511,0	-87,7	23,6
8	Нийгмийн даатгалын шимтгэл	224,3	231,0	6,7	3,6
9	Цахилгаан	332,5	297,1	-35,4	4,6




10	Дулаан	43,6	14,2	-29,4	0,2
11	Байгаль орчин нөхөн сэргээх	51,8	50,2	-1,6	0,8
12	Ус	7,9	9,7	1,8	0,2
13	Ус ашигласны төлбөр	19,9	39,5	19,6	0,6
14	Газрын төлбөр	18,1	19,6	1,5	0,3
15	АМНАТөлбөр	168,8	170,5	1,7	2,7
16	Тээврийн хэрэгслийн татвар	5,9	3,9	-2,0	0,1
17	Үлд хөдлөх хөрөнгийн татвар	17,8	17,9	0,1	0,3
18	Албан томилолт	35,2	29,6	-5,6	0,5
19	Бичиг хэрэг	9,9	5,6	-4,3	0,1
20	Холбоо	14,8	2,1	-12,7	0,0
21	Хөдөлмөр хамгаалал	100,8	97,1	-3,7	1,5
22	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил	85,0	56,9	-28,1	0,9
23	Гэрээт харуул хамгаалалт	82,5	82,5	0,0	1,3
24	Үндсэн хөрөнгийн элэгдэл	683,8	642,4	-41,4	10,0
25	Банкны зээлийн хүү	28,2	26,8	-1,4	0,4
26	Бусад зардал	157,2	62,1	-95,1	1,0
	<b>Үйл ажиллагааны зардал</b>	<b>6739,6</b>	<b>6415,0</b>	<b>-324,6</b>	<b>100,0</b>
27	Удирдлагын зардал	490,9	583,4	92,5	
28	Үйл ажиллагааны бус зардал	529,7	891,0	361,3	
	<b>Бүрэн өөрийн өртөг</b>	<b>7760,2</b>	<b>7889,4</b>	<b>129,2</b>	

2018 оны үйл ажиллагааны зардлыг доорх графикаар харууллаа. Үйл ажллагааны зардлын 14.5 хувийг түлш, 21.7 хувийг сэлбэг, 23.6 хувийг цалин, 10.0 хувийг элэгдлийн зардал, 30.2 хувийг бусад зардал эзэлж байна.



### Үйл ажиллагааны зардал



■ түлш ■ сэлбэг ■ цалин ■ элэгдэл ■ бусад

Үйл ажиллагааны зардлын 14.5 хувийг түлшний зардал эзэлж байна. 2018 онд зарцуулсан түлшний хэмжээ өмнөх оноос 47.9 мян.литр түлш бага зарцуулсан боловч үнэ өссөнтэй холбоотой өмнөх оноос өссөн үзүүлэлттэй байна. Дараах хүснэгтээр дэлгэрэнгүй харуулав.

/сая.төг-р/

Түлш	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	Дүн
2017 он	55.0	42.2	40.1	44.4	79.1	96.6	76.6	97.2	100.8	88.3	69.7	51.8	841.8
2018 он	52.9	38.8	49.8	56.5	76.3	93.4	82.0	98.8	94.0	110.7	102.9	85.3	941.4
Зөрүү	-2.1	-3.4	9.7	12.1	-2.8	-3.2	5.4	1.6	-6.8	22.4	33.2	33.5	99.6

Түлшний зарцуулалтыг доорх хүснэгтэнд литрээр харууллаа.

/мян.литр-р/

Түлш	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	Дүн
2017 он	39.1	29.9	28.3	31.5	56.1	68.7	54.3	69.1	70.0	61.6	45.9	34.1	588.6
2018 он	34.7	25.3	30.5	34.5	46.4	56.9	49.5	58.6	53.6	62.1	48.7	40.0	540.7
Зөрүү	-4.4	-4.6	2.2	3.0	-9.7	-11.8	-4.8	-10.5	-16.4	0.4	2.8	5.9	-47.9

✓ Цалингийн зардал нийт дүнгээрээ тайлант хугацаанд 2 030.8 сая.төг гарч өнгөрсөн оноос 51.7 сая.төг-өөр буурсан үзүүлэлттэй байна. Доорх хүснэгтээс харахад цагаар цалин, хийснээр цалин,шагналт цалин,амралтын цалин,сарын үр дүнгийн цалин өсч, харин наряд цалин, илүү цаг, шөнийн цагийн нэмэгдэл цалин өнгөрсөн оны мөн үеэс буурсан байна.



Цалин ангилал	Х/нэгж	2017 он	2018 он	Зөрүү /2017-с/
Үндсэн	сая.төг	<b>1 049,6</b>	<b>998,4</b>	- 51,2
Цагаар цалин	сая.төг	223,6	236,1	12,5
Хийснээр цалин	сая.төг	30,3	38,3	8,0
Наряд	сая.төг	355,8	298,9	- 56,9
<b>Дүн</b>		<b>439,9</b>	<b>425,1</b>	- <b>14,8</b>
<b>Нэмэгдэл цалин</b>				
Илүү цаг	сая.төг	123,9	106,4	- 17,5
Шөнө цаг	сая.төг	34,6	9,8	- 24,8
Шагналт цалин	сая.төг	139,1	146,5	7,4
Удаан жил	сая.төг	194,4	174,6	- 19,8
Амралт	сая.төг	175,9	186,3	10,4
Сарын үр дүн	сая.төг	287,0	338,8	51,8
Бусад	сая.төг	78,0	70,0	- 8,0
<b>Дүн</b>		<b>1 032,9</b>	<b>1 032,4</b>	- 0,5
<b>Нийт цалин</b>		<b>2 082,5</b>	<b>2 030,8</b>	- <b>51,7</b>

Компанийн хэмжээнд 1 хүний сарын дундаж цалин 2017 онд 1022.9 байсан бол 2018 онд 1 050.4 мян.төгрөг гарч байна. Үүнийг хэсэг тус бүрээр задалж харуулбал:


Дундаж цалин	2017 он	2018 он
Авто засварын хэсэг	1 321,5	1 238,2
Уулын хэсэг	1 176,7	1 265,5
Захиргаа	1 117,7	1 270,5
Цахилгаан сантехникийн хэсэг	993,5	1 087,8
Туслах аж ахуй	722,3	810,9
Цайны газар	1 099,5	894,5
Харуул, үйлчилгээ	729,1	785,4
<b>компанийн хэмжээнд дундаж цалин</b>	<b>1 022,9</b>	<b>1 050,4</b>

Удирдлагын зардлыг өнгөрсөн онтой харьцуулахад 92.5 сая.төг-р өссөн байна. Үүнд: Цалингийн зардал 31.3 сая.төгрөг, томилолтын зардал 18.2 сая төгрөг, сэлбэгийн зардал 4.6 сая төгрөг, шуудан холбооны зардал 11.8 сая төгрөг, шатахууны зардал 1.2 сая төгрөг, бусад зардал 18.2 сая төгрөгөөр тус тус өссөн байна.



Зардлын төрөл	2017	2018	Зөрүү	Тайлбар
Цалин хөлс, шагнал	392,8	424,1	31,3	2018 онд сарын үр дүнгийн цалин нэмэгдсэнтэй холбоотой өссөн.
Нийгмийн даатгалын зардал	49,1	53,4	4,3	-
Албан томилолтын зардал	2,8	21,0	18,2	2017 онд зөвхөн гүйцэтгэх захирлын зардал байсан бол 2018 онд хэсгийн дарга нарын томилолт нэмэгдэж орсон.
Сэлбэг материалын зардал	0,3	4,9	4,6	2017 онд benz машины зардалд 0,3 сая төгрөг, 2018 онд 98-88 машины бүх сэлбэгийн зардал гарсан байна.
Шуудан холбооны зардал	0,8	12,6	11,8	2017 онд 70582125 дугаарын төлбөр бүртгэдэг байсан бол 2018 онд интернет болон модемын төлбөр нэмэгдэж бүртгэгдсэн.
Шатахууны зардал	38,0	39,2	1,2	98-88 машины шатахууны зардал.
Бусад зардал	3,0	21,2	18,2	2017 оны аудитын үйлчилгээний төлбөр-5,5 сая, санхүүгийн программын шинэчлэлт үнэ-7,4 сая, банкны шимтгэл гэх мэт зардлууд орсон байна.
Хангамжийн материал	3,5	5,1	1,6	-
Бичиг хэргийн зардал	0,7	1,9	1,2	-
<b>Дүн</b>	<b>490,9</b>	<b>583,4</b>	<b>92,5</b>	





**Үйл ажиллагааны нэгжийн өртөг:**

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2017 он	2018 он	Зөрүү
Нүүрс олборлолт	тн	526,4	533,6	7,2
Бүрэн өөрийн өртөг	төг	7760,2	7889,4	129,2
1 тн нүүрсний өртөг	төг	14 742,0	14 785,2	43,2

1 тн нүүрсний өртөг 2017 онд 14 742.0 төгрөг байсан бол тайлант хугацаанд 14 785.2 төгрөг болж 43.2 төгрөгөөр өссөн байна.

**Орлого:**

Тайлант хугацаанд нийт орлого 8 540.0 сая.төг, үүнээс нүүрсний орлого 6 819.3 сая.төг, тээврийн орлого 1 385.1 сая.төг, бусад орлого 335.6 сая.төг байна. Өмнөх онтой харьцуулбал нийт орлого 259.2 сая.төг-р өссөн. Үүнээс ахуй хэрэглэгчдийн орлого 247.9 сая.төгрөгөөр буурсан, Станцад нийлүүлсэн нүүрсний орлого 313.3 сая.төг-өөр, тээврийн орлого 140.0 сая.төг-өөр, бусад орлого 53.7 сая.төг-өөр тус тус өссөн байна.

Гол хэрэглэгч болох ДБЭХС ТӨХК-с нүүрс борлуулалтанд 5 858.5 сая.төг, тээврээс 1 385.1 сая.төг-ийн орлого, ААНэгж, айл өрхөөс нүүрсний орлого 960.8 сая.төгрөгийн орлого тус тус олсон байна.

Орлогын өсөлт нь нүүрсний биет хэмжээний өсөлтөөс шууд хамааралтай.

✓ Өнгөрсөн онтой харьцуулахад “ДБЭХС” ТӨХК-д нийлүүлсэн нүүрсний биет хэмжээ 7,2 мян.тн-р өссөн байна.

✓ Ахуйн хэрэглэгчдэд нийлүүлсэн нүүрсний борлуулалт өнгөрсөн онтой харьцуулахад биет хэмжээгээр 17.7 мян.тн-р буурсан.



✓ Тээврийн орлого нь станцад нийлүүлсэн нүүрсний биет хэмжээ өсөхөд дагаж өссөн байна.

Орлого	Х/нэгж	2017 он	2018 он	Харьцуулалт	
				тоо	%
Нүүрсний борлуулалт	сая.төг	6 753,9	6 819,3	65,4	1,0
Станц	сая.төг	5 545,2	5 858,5	313,3	5,6
Ахуй	сая.төг	1 208,7	960,8	- 247,9	- 20,5
Тээврийн орлого	сая.төг	1 245,1	1 385,1	140,0	11,2
Бусад орлого	сая.төг	281,9	335,6	53,7	19,0
<b>Нийт</b>	сая.төг	<b><u>8 280,8</u></b>	<b><u>8 540,0</u></b>	<b><u>259,2</u></b>	<b><u>3,1</u></b>

#### Үр ашиг, алдагдал:

Компани тайлант хугацаанд үйл ажиллагаандаа нийт 8 540.0 сая.төг-ийн орлого олж, 7 889.4 сая.төг-ийн зардал гаргаж, татвар төлөхийн өмнөх ашиг 650.6 сая.төг гарсан. Өнгөрсөн онтой харьцуулахад татвар төлөхийн өмнөх ашиг 130.0 сая.төг-р өссөн байна.

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2017 он	2018 он	Харьцуулалт	
				зөрүү	%
Нийт орлого	сая.төг	8 280,8	8 540,0	259,2	3,1
Нийт зардал	сая.төг	7 760,2	7 889,4	129,2	1,7
Татвар төлөхийн өмнөх ашиг	сая.төг	520,6	650,6	130,0	25,0
Орлогын татварын зардал	сая.төг	85,1	103,5	18,4	21,6
Татварын дараах ашиг	сая.төг	435,5	547,1	111,6	25,6